



2004 оны 10 дугаар сарын Цуврал



Нээлттэй Нийгэм Форум (ННФ) болон ЭЗБШӨЧ төслөөс дотоодын хувийн хөрөнгө оруулалтын аз турших капиталын санг байгуулах боломжийн талаар хийсэн техник, эдийн засгийн судалгаа, дүгнэлтийг танилцуулав

Энэ оны 10 дугаар сарын 13-ны өдөр судалгааны багийнхан дотоодын хувийн хөрөнгө оруулалтын аз турших капиталын санг Монгол улсад байгуулах техник, эдийн засгийн боломжийн талаар хийсэн судалгаа, дүгнэлтийг олон нийтэд танилцуулав. Багийн

санхүүжүүлээ. Судалгааны багийн бүрэлдэхүүнд ноён Грабаас гадна тус төслийн санхүү, бизнесийн мэргэжилтэн Дашнямын Ашидмаа, ННФ-ын менежер Баатаржавын Мөнхсоёл, *ᠶᠡᠯᠡᠭᠡᠨᠡᠨᠢᠯᠡᠭᠡᠨᠡᠨᠢᠯᠡᠭᠡᠨ* дадлага хийж буй Баяртогтохын Энхбаяр нар ажиллав.


Өсөх ирээдүйтэй компаниудын талаар хийсэн судалгаа, мөн тэдний хөрөнгө оруулалт хийх хүсэл, эрмэлзлэлээ урьдчилан илэрхийлсэн байдалд тулгуурлан, мөн дараагийн үе шатнаас сэтгэл хангахуйц үр дүн гарах тохиолдолд Монголд хувийн хөрөнгө оруулалтын аз турших сан байгуулах боломжтой гэсэн дүгнэлтийг судалгааны багаас гаргасан байна.

Хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалт хийх хүсэл, эрмэлзлэлийг бататгах сангийн танилцуулга гаргахын тулд компаниудын тухай болон тэдний санхүүгийн байдал, өсөх ирээдүйн талаар нарийвчилсан мэдээллийг цаашид гаргах шаардлагатай. Хэрэв дүн шинжилгээний дараагийн шатнаас эерэг дүгнэлт гарвал, аз турших капиталын санг нэг жилийн дотор байгуулж болно гэсэн дүгнэлтийг багийн зүгээс хийлээ.

Хэдийгээр энэхүү урьдчилсан судалгаа нь боломжит компаниудыг судлахад үндсэндээ чиглэгдэж, сангийн хөрөнгийг бий болгох хөрөнгө оруулагчдын сонирхлыг нарийвчлан судлаагүй боловч урьдчилсан байдлаар 4 сая орчим ам. долларын хөрөнгө оруулалтыг тодорхой нөхцөл, болзлын дагуу хийх урьдчилсан амлалтыг үндсэн хөрөнгө оруулагчдаас аваад байна.

Энэхүү анхдагч хөрөнгө оруулагчдын хүсэл, сонирхол, компаниудын талаар хийсэн урьдчилсан дүгнэлтэнд үндэслэн доорх асуудлыг анхааран үзэж, дараах шатны арга хэмжээ авахыг санал болгож байна. Үүнд:

1. Цаашид өсөх ирээдүйтэй компаниудын талаар нарийвчлан судлах. Үүнд: өсөх боломжийн талаар нарийвчлан судлан үнэлгээ өгөх, санхүүгийн тайлантай танилцах (орлогын тайлан, тайлан баланс, мөнгөн урсгалын тайлан болон өгөөжийн хэмжээ), менежментийн зохицуулалт, өөрийн хөрөнгийн болон



ахлагч, хөрөнгө оруулагч банкир, аз турших капиталын хөрөнгө оруулалтын мэргэжилтэн ноён Деннис Граб хийсэн ажлынхаа үр дүнгийн талаар мэдээллээ.

ᠶᠡᠯᠡᠭᠡᠨᠡᠨᠢᠯᠡᠭᠡᠨᠡᠨᠢᠯᠡᠭᠡᠨ нь судалгааны багийн үйл ажиллагааг хамтран ивээн тэтгэж

